



МОНГОЛ УЛСЫН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
САЙД

13361 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 16а Засгийн газрын IX байр,
Утас: 26 22 71. Факс: (976-51) 26 32 37,
E-mail: mofa@mofa.gov.mn; http://www.mofa.gov.mn

2015. 10. 06. № 01/3145

танай _____-ны № _____-г

УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙГАЛЬ
ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНД

Тус байнгын хороогоор 2015 оны ургац
хураалтын ажлыг эрчимжүүлэхээр зохион байгуулж
байгаа ажил, цаашдын зорилтын талаар хэлэлцэхтэй
холбоотой мэдээллийг хүргүүлж байна.

Хавсралт ~~/~~ хуудастай.



00001953

Орхон-Увс аймгийн албан бичгүүд 5-15.срх

**УРГАЦ ХУРААЛТЫН ЯВЦ, ЦААШИД АВАХААР ЗОХИОН БАЙГУУЛЖ
БАЙГАА АЖЛЫН ТАНИЛЦУУЛГА**

2015.10.05

Нэг. Ургац хураалтын явцын товч мэдээ

2015 онд улсын хэмжээгээр 389.3 мянган га-д үр тариа, үүнээс 360.7 мянган га-д буудай, 12.5 мянган га-д төмс, 7.1 мянган га-д хүнсний ногоо, 78.5 мянган га-д тосны ургамал, 19.5 мянган га-д тэжээлийн ургамал, 5.4 мянган га-д эмийн ургамал, нийтдээ 512.3 мянган га-д тариалалт хийсэн.

Урьдчилсан балансаар 265.0 мянган тонн үр тариа, үүнээс 252.3 мянган тонн буудай, 117.3 мянган тонн төмс, 75.3 мянган тонн хүнсний ногоо, 28.7 мянган тонн тосны ургамал, 53.9 мянган тонн малын тэжээлийн ургамал тус тус хураан авч гурил үйлдвэрлэлд 186.3 мянган тонн буудай нийлүүлэх төлөв гарсан.

Төмс, хүнсний ногооны хураалт 8 дугаар сарын 25-наас, Үр тариа, тэжээлийн таримлын хураалт 9 дүгээр сарын 08-наас жигдэрч эхэлсэн.

Ургац хураалтад нийтдээ 1123 комбайн, 599 жатка, 826 үтрэмийн техник, 463 төмс, хүнсний ногоо хураах техник ажиллаж байна. Ургац хураалтын ажилд 1100 гаруй цэргийн албан хаагч 650 оюутан залуучууд гэрээгээр ажиллаж байна.

10 дугаар сарын 02-ний байдлаар Улаанбуудайн хураалт 37,6 хувьтай, төмсний хураалт 75.6 хувьтай, хүнсний ногооны хураалт 74.7 хувьтай явагдаж байна.

Нийтдээ 108.3 мянган га-гаас 92.0 мянган тонн буудай, 9.2 мянган га-гаас 112.5 мянган тонн төмс, 4.8 мянган га-гаас 52.8 мянган тонн хүнсний ногоо, 10.8 мянган га-гаас 16.5 мянган тонн тэжээл, 8.2 мянган га-гаас 4,4 мянган тонн тосны ургамал тус тус хураан аваад байна. Энэ нь нэг га талбайгаасаа 8.3 цн буудай, 110.5 цн төмс, 107.4 цн хүнсний ногоо, 17.0 цн малын тэжээлийн ургамал тус тус хураан авч байгаа үзүүлэлт юм.

(Хураасан талбайн хэмжээг хүснэгтээр үзүүлэв.)

| УРГАЦ ХУРААЛТЫН МЭДЭЭ | | | | | | |
|------------------------------|------------------------|--------------------|----------------------|-------------|--------------------|-----------------|
| Д/Д | Таримлын төрөл | Хураах талбай (га) | Хураасан талбай (га) | Хувь | Нэгжийн ургац (цн) | Нийт ургац (тн) |
| 1 | Үр тариа | 297407 | 110445 | 37.1 | 8.5 | 93395 |
| | Үүнээс: Улаанбуудай | 287300 | 108300 | 37,6 | 8.3 | 92055 |
| 2 | Төмс | 12177 | 9208 | 75.6 | 122.2 | 112560 |
| 3 | Хүнсний ногоо | 6463 | 4830 | 74.7 | 109.5 | 52879 |
| 4 | Тэжээл | 53718 | 10835 | 20.1 | 14.8 | 16053 |
| 5 | Тосны ургамал | 55186 | 8258 | 14.9 | 6.8 | 4456,8 |

Өнгөрсөн оны мөн үед үр тарианы хураалт 76.4 хувь, төмс, хүнсний ногооны хураалт 82.4-90.4 хувь, тэжээлийн таримлын хураалт 70.0 хувьтай явагдаж байсан бол энэ жилийн

хувьд таримлын болцтой холбоотойгоор ургац хураалтын ажлын харьцангуй удаашралтай явагдаж байна.

Хоёр. Ургац хураалтад нөлөөлж байгаа хүчин зүйлүүд

1. Газар тариалангийн бүс нутгаар 5 дугаар сард хүйтэн сэрүүн, хур тунадас багатай, 6 дугаар сард олон хоног үргэлжилсэн аагим халуун болсон, ялангуяа таримал ургамлын чийгэнд хамгийн эмзэг үе болох бутлалтаас гол хатгалтын үе буюу 6 дугаар сарын 10-наас 7 дугаар сарын 08-ныг хүртэлх хугацаанд тариалангийн гол бүс нутгаар агаарын хамгийн их температур 34-38 градус, хөрсөн дээрх хамгийн их температур 60-64 градуст хүрч 18-27 хоног үргэлжилсэн нарны хэт их халалт явагдсан нь гангийн нөхцлийг үүсгэсэн, түүнчлэн 8 дугаар сарын 12-ноос 9 дүгээр сарын 11-ийг хүртэл тариалангийн бүс нутгаар ахиу хэмжээний хур тунадас орж, дулаан байсан нь тариа хэнэлэх, хог ургамал их хэмжээгээр түрж ургах нөхцлийг бий болгосон.

2. Өмнөх жилүүдийн цаг агаарын таатай нөхцлийг давтагдах мэтээр төсөөлж зарим тариаланчид гуурсанд ихээр тариалсан. Мэргэжлийн агрономч, инженерүүдийг авч ажилуулдаггүй, технологийн ажлын удирдлага дутсан.

3. Орбит комплекс зэрэг зарим гурилын үйлдвэрүүд 2014 онд худалдан авсан буудайнаа төлбөрийн үлдэгдлийг тариаланчдад олгоогүй нь жижиг тариаланчдад санхүүгийн хүндрэл үүсгэсэн.

4. Хөрсийг элэгдлээс хамгаалах, чийгийн алдагдлыг багасгах дэвшилтэт технологиудыг нэвтрүүлэх ажил удаашралтай, бордооны хангамж, хэрэглээ дутагдалтай байгаа зэрэг байгалийн болон хүний хүчин зүйл энэ жилийн ургацад сөрөг нөлөө үзүүлж байна.

Гурав. Ургац хураалтыг эрчимжүүлэхээр зохион байгуулж байгаа ажлууд

Ургац хураалтын талбайн ажлыг 10 дугаар сардаа багтаан дуусгах төлөвлөгөөтэйгээр ажиллаж байна. Энэ дагуу дараахь ажлуудыг хэрэгжүүлж байна.

1. Таримлын болц оройтосон, ургамлын иш намхан байгаатай холбоотойгоор аж ахуйн нэгж бүр өөр өөр арга техник, технологийг хэрэглэж байна. Ялангуяа ангилан хадах боломжгүй хэт намхан, хэнзлэн ургасан тариаг хураахын тулд химийн аргаар болц түргэтгэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх, ургац хураалтын ажлыг эрчимжүүлэх, төмс, хүнсний ногоог хөлдөж хайрагдахаас сэргийлэх, ангилан хадсан талбайн хураалтыг шуурхайлах чиглэлийг орон нутгийн удирдлагуудад өгч байна.

2. Буудайн борлуулалтыг дэмжих, хүн амын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах, хангамжийг тогтвортой хадгалах улмаар 2016 оны тариалалтад зориулан чанар сайтай үрийн нөөц бүрдүүлэх, малын тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зорилгоор асуудал боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн "Хүнсний болон үрийн буудайн нөөц" бүрдүүлэхэд 80.0 тэрбум, "Тэжээлд шилжүүлсэн үр тарианы талбайгаас ногоон тэжээл" бэлтгэхэд 8.0 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийн эх үүсвэрийг тус тус шийдвэрлүүлсэн болно.

3. Монгол Улсын Засгийн газрын 322 дугаар тогтоолын дагуу 106.0 мянган тонн хүнсний улаанбуудай, 20 хүртэл мянган тонн үрийн улаанбуудайн нөөц бүрдүүлэхэд шаардагдах 80.0 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэх чиглэлээр Сангийн яам болон Хөгжлийн банктай хамтран ажиллаж байна.

Мөн Тариалан эрхлэлтийг дэмжих санд 10,0 мянган тонн үрийн улаанбуудай, 20 мянган тонн хүнсний улаанбуудай худалдан авах 20,0 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр төсвийн тодотголд саналаа оруулсныг дэмжүүлэх саналтай байна.

Импортоор авах хүнсний болон үрийн буудайг гадаад талдаа нэг цонхны бодлогоор хэрэгжүүлэх, харин дотоод талдаа ТЭДСан болон гурилын үйлдвэрүүдийн хамтарсан хэлцэлээр хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

4. Монгол Улсын Засгийн газрын 323 дугаар тогтоолоор тэжээлд шилжүүлсэн үр тарианы талбайгаас ногоон тэжээл бэлтгэх, рапсын шахдас болон хаман боогч худалдан авахад шаардагдах 8.6 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Хөгжлийн банкнаас эргэлтийн хөрөнгийн зээлийн гэрээ байгуулан санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд Хөгжлийн банк нь ногоон тэжээл худалдан авахад шаардагдах эргэлтийн хөрөнгийн зээлийн эх үүсвэрийг шийдвэрлэх боломжгүй гэсэн хариу өгсөн болно.

Иймд үүссэн нөхцөл байдалтай уялдуулан холбогдох агентлагуудын удирдлагуудтай зөвшөлцсөний үндсэн дээр Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон Онцгой байдлын ерөнхий газрын Улсын нөөцийн газар хооронд үүссэн өр авлагын тооцоонд хамруулан 4.0 тэрбум төгрөгийн ногоон тэжээлийг худалдан авч нөөц бүрдүүлэх, үлдэх 4.6 тэрбум төгрөгт нь ногоон тэжээл болон рапсын шахдас, хаман боогч худалдан авахаар тооцож төсвийн тодотголд тусган оруулсан болно.

5. Хүнс, хөдөө аж хуйн сайдын 2015 оны А-119 дүгээр тушаалаар Тариалан эрхлэлтийг дэмжих санд 2015 оны ургацаас худалдан авч болон авлагад тооцож авах нэг тонн үрийн улаанбуудайн үнийг 780,0 мянган төгрөгөөр тогтоосон. Хүнсний улаанбуудайн хувьд гурил үйлдвэрлэгчид тариаланчдын хоорондын худалдан авалтын үнийг үндэслэнэ. Урамшууллын хэмжээг журмын дагуу ургац хураалтын дараа засгийн газраас тогтооно.

Дөрөв. Цаашид анхаарах арга хэмжээний санал

1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон тариалангийн технологи хэлэлцүүлгийг төрийн болон төрийн бус байгууллага, эрдэмтэн судлаачид тариаланчидын дунд зохион байгуулж одоогоор нэвтрүүлж байгаа цомхотгосон ба тэг элдэншүүлгийн технологид гаргаж байгаа алдааг засах, болц түргэтгэх ангилан хадалт бүхий механик аргатай химийн аргыг хослуулах, хөрсний үржил шимийг шинжилсний үндсэн дээр ямар төрлийн бордоог ямар тунгаар яаж хэрэглэх, бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх зэрэг асуудлыг хэлэлцэх

2. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнийн үйлдвэрлэлийг механикжуулж, хангамжийг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхдээ хадгалалт борлуулалтын логистик сүлжээний менежментийн бүтцийг бүрдүүлж, бодлогоор дэмжих,

Хууль эрх зүйн хүрээнд:

1. УИХ-аас 2008 онд баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг 2015 оны 07 дугаар сарын 09 хуулиар хүчингүй болгосонтой холбоотойгоор хуулийг хэрэгжилтийн хугацааг сунгах,
2. УИХ-д өргөн бариад байгаа Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын баримт бичгийг батлуулах,
3. "Тариалангийн тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-аар хэлэлцүүлэн батлуулах,
4. "Газар тариалангийн тогтвортой хөгжил" хөтөлбөрийг Засгийн газраар батлуулах.
5. "Тариалангийн даатгалын тухай" хуулийн төслийг боловсруулах ажлыг түргэтгэх

УРГАЦ ХУРААЛТЫН ЯВЦЫН МЭДЭЭ

10/5/2015

| Д/д | Аймгийн нэр | Үр тариа | | | | | Тэмс | | | | | Хүнсний ногоо | | | | | Тэжээлийн ургамал | | | Тосны ургамал | | |
|------------|-------------|------------------------|-------------------------|------|----------------------|-------------------|------------------------|-------------------------|------|----------------------|-------------------|------------------------|-------------------------|-------|----------------------|-------------------|------------------------|-------------------------|--------------------|-----------------------|-------------------------|--------------------|
| | | Хураах талбай га -гаар | Хураасан талбай га-гаар | Хувь | нэгжийн ургац цт-ээр | Нийт ургац тн-оор | Хураах талбай га -гаар | Хураасан талбай га-гаар | Хувь | нэгжийн ургац цт-ээр | Нийт ургац тн-оор | Хураах талбай га -гаар | Хураасан талбай га-гаар | Хувь | нэгжийн ургац цт-ээр | Нийт ургац тн-оор | Хураах талбай га -гаар | Хураасан талбай га-гаар | Авсан ургац тн-оор | Хураах талбай га-гаар | Хураасан талбай га-гаар | Авсан ургац тн-оор |
| 1 | Архангай | 3072 | 1780 | 57.3 | 8.4 | 1120 | 400 | 380 | 95.0 | 70.0 | 2660 | 120 | 90 | 75.0 | 70.0 | 630 | 2485 | 760 | 1140 | 1280 | 200 | 150 |
| 2 | Баян-Өлгий | 0 | 47.5 | 0.0 | 11.9 | 56.3 | 285 | 281.7 | 98.8 | 97.3 | 2739.9 | 115 | 122.2 | 106.3 | 91.5 | 1118.4 | 304 | 455.2 | 1069.5 | 0 | 0 | 0 |
| 3 | Баянхонгор | 18 | 12 | 66.7 | 8.3 | 10 | 242 | 179 | 74.0 | 112.4 | 2012 | 187 | 138 | 36.0 | 92.8 | 1281 | 561 | 363 | 840 | 0 | 0 | 0 |
| 4 | Булган | 33464 | 11607 | 34.7 | 9.3 | 10814 | 495 | 370 | 74.7 | 91.7 | 3393 | 256 | 199 | 77.7 | 90.7 | 1804 | 309 | 21 | 30 | 1835 | 20 | 20 |
| 5 | Говь-Алтай | 305 | 265.6 | 87.1 | 9.7 | 267.6 | 89 | 75.4 | 84.7 | 82.4 | 621.4 | 78 | 55.5 | 71.2 | 56.5 | 313.7 | 454 | 403.9 | 1162 | 0 | 0 | 0 |
| 6 | Дорноговь | 0 | 0 | 0.0 | 0.0 | 0 | 31 | 18 | 58.1 | 69.4 | 126 | 37 | 22 | 59.5 | 65.0 | 143 | 17 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 7 | Дорнод | 28730 | 7165 | 24.9 | 9.3 | 6657 | 233 | 108.1 | 46.4 | 76.3 | 824.6 | 132 | 84.6 | 64.1 | 105.6 | 893.7 | 218 | 50 | 60 | 14170 | 4740 | 2806 |
| 8 | Дундговь | 0 | 0 | 0.0 | 0.0 | 0 | 28 | 15.9 | 56.8 | 40.0 | 63.6 | 13.4 | 9 | 67.2 | 0.0 | 28 | 25 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| 9 | Завхан | 840 | 600 | 71.4 | 9.0 | 540 | 212 | 186.1 | 87.8 | 88.8 | 1652.8 | 116 | 105.7 | 49.0 | 96.4 | 1019.1 | 1119 | 815.5 | 975.8 | 0 | 0 | 0 |
| 10 | Өвөрхангай | 3985 | 180 | 4.0 | 10.5 | 188 | 358 | 320 | 89.4 | 115.8 | 3704 | 194 | 168 | 86.6 | 138.6 | 2329 | 804 | 526 | 927 | 1200 | 342 | 55 |
| 11 | Өмнөговь | 0 | 0 | 0.0 | 0.0 | 0 | 45 | 40 | 88.9 | 95.0 | 380 | 59 | 42 | 71.2 | 85.7 | 360 | 20 | 0 | 5 | 0 | 0 | 0 |
| 12 | Сүхбаатар | 8796 | 78 | 0.0 | 3.2 | 25 | 80 | 72 | 90.0 | 102.1 | 735 | 34 | 30 | 88.2 | 103.7 | 311 | 620 | 0 | 0 | 2970 | 560 | 250 |
| 13 | Сэлэнгэ | 119016 | 60738 | 51.0 | 8.2 | 49632 | 2839 | 2297.8 | 80.9 | 138.6 | 31866 | 2070 | 1570.4 | 75.9 | 131.1 | 20591 | 19404 | 600 | 1400 | 19642 | 1488 | 805 |
| 14 | Төв | 51914 | 8040 | 15.5 | 8.3 | 6662 | 4236 | 3126 | 73.8 | 135.2 | 42249 | 372 | 241.7 | 65.0 | 97.8 | 2363 | 16561 | 2495 | 3255 | 8104 | 100 | 50 |
| 15 | Увс | 4557 | 4056 | 89.0 | 9.0 | 3633 | 238 | 130 | 54.6 | 135.0 | 1755 | 249 | 140 | 56.2 | 141.4 | 1980 | 2206 | 1600 | 2520 | 150 | 0 | 0 |
| 16 | Ховд | 112 | 75 | 67.0 | 9.1 | 68 | 750 | 476 | 63.6 | 141.8 | 6760 | 720 | 465 | 64.6 | 124.2 | 5773 | 218 | 280 | 280 | 0 | 0 | 0 |
| 17 | Хөвсгөл | 14720 | 7512 | 51.0 | 7.7 | 5763 | 320 | 279 | 87.2 | 78.7 | 2196 | 260 | 174 | 66.9 | 72.8 | 1267 | 369 | 278 | 551 | 1497 | 328 | 164 |
| 18 | Хэнтий | 14327 | 1600 | 11.2 | 9.0 | 1435 | 326 | 220 | 67.6 | 122.7 | 2700 | 169 | 130 | 76.9 | 95.2 | 2100 | 4161 | 1000 | 700 | 930 | 220 | 40 |
| 19 | Дархан-Уул | 9792 | 3710 | 37.9 | 6.5 | 2424.5 | 299 | 279 | 93.3 | 78.0 | 2176.2 | 626 | 502 | 80.2 | 52.0 | 2610.4 | 3293 | 1342 | 1073 | 3363 | 240 | 100.8 |
| 20 | Улаанбаатар | 0 | 0 | 0.0 | 0.0 | 0 | 426 | 176 | 41.3 | 140.3 | 2469 | 471 | 330 | 70.1 | 120.0 | 3960 | 210 | 30 | 43 | 0 | 0 | 0 |
| 21 | Орхон | 3759 | 3021 | 80.4 | 13.7 | 4127 | 255 | 177.6 | 69.6 | 83.8 | 1487.9 | 189 | 209.1 | 110.6 | 94.3 | 1971 | 359 | 15 | 22 | 45 | 20 | 16 |
| 22 | Говьсүмбэр | 0 | 0 | 0.0 | 0.0 | 0 | 6 | 1.1 | 18.3 | 85.4 | 9.5 | 18 | 2.1 | 13.1 | 156.7 | 32.9 | 1 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| ДҮН | | 297407 | 110445 | 37.1 | 8.5 | 83392.4 | 12177 | 9208.7 | 75.6 | 122.2 | 112560 | 6463.4 | 4830.3 | 74.7 | 109.5 | 52879 | 53718 | 10835 | 16053 | 55186 | 8258 | 4456.8 |
| 2014.10.03 | | 311560 | 238015 | 76.4 | 15.1 | 365370 | 13311 | 12033 | 90.4 | 124.8 | 150117 | 8195 | 6756 | 82.4 | 120.6 | 81055 | 12105 | 9073 | 27956 | 79420 | 42112 | 28679 |